



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай танилцуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

... Коронавирусын цар тахлын нөлөөгөөр “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн олон улсын хуваарьт нислэгийг 2020 оны 2 дугаар сараас эхлэн зогсоосноор компани 2020 онд 58.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хуримтлагдсан өр төлбөрийн хэмжээ 48.2 тэрбум төгрөгт хүрч, 2021 оны 3 дугаар улиралд мөнгөн хөрөнгийн дутагдалд орж, үйл ажиллагаа нь зогсох эрсдэл тулгараад байна.

Иймд агаарын тээврийн салбарт үүссэн давагдашгүй хүчин зүйлийг харгалзан Үндэсний агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа зогсох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн бодлогоор дэмжих асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх нь зүйтэй” гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



13201052